

Golomt Capital®

ДЭЛХИЙН

ЗАХ ЗЭЭЛИЙН ДОЛОО
ХОНОГИЙН ТОЙМ

2025.09.01

Хөрөнгийн зах зээлийн онцлох мэдээ

ТОВЧ

- NVIDIA тайлангийн үзүүлэлтүүд нь хиймэл оюун ухаан салбарын сүүлийн үеийн болгоомжлолыг намжаахуйц хангалттай хүчтэй байлаа.
- АНУ-ын Ерөнхийлөгч Дональд Трамп Холбооны нөөцийн захирагч Лиза Күүкийг моргейжийн луйвар үйлдсэн гэх мэдэгдлээр огцруулна гэж зарлалаа.
- Кристофер Уоллер, хамгийн сүүлийн хурлын үеэр 25 суурь нэгжээр (0.25 хувь) бодлогын хүүг бууруулахыг санал болгосон.
- CSI 300 зөвхөн наймдугаар сард ойролцоогоор 10%-иар өсөж, томоохон индексүүдийн дундаас хамгийн сайн гүйцэтгэлтэйд тооцогдож байгаа бөгөөд энэ сарын дундаж өдөр тутмын арилжааны хэмжээ түүхэн дээд түвшинд хүрэх төлөвтэй байна.

S&P 500 индексийн
2025 оны таамаглал

Deutsche Bank	7,000
Société Générale	6,750
BMO Capital Markets	6,700
Bank of America	6,666
Barclays	6,600
RBC Capital Markets	6,600
Wells Fargo	6,500
Citigroup	6,500
Goldman Sachs	6,500
Morgan Stanley	6,500
JPMorgan Chase	6,500
UBS	6,400
Дундаж	6,678





АНУ-ын зах зээлийн онцлох мэдээ 2025.08.24-08.31

NVIDIA ТАЙЛАН ХҮЛЭЭЛТЭЭС ӨНДӨР ГАРЛАА.

Эдийн засгийн мэдээний урсгал долоо хоногийн эхэнд харьцангуй бага байсан бөгөөд анхаарал ихэнхдээ л чип үйлдвэрлэгч NVIDIA-гийн лхагва гарагийн зах зээл хаасны дараа гаргасан тайланд төвлөрөв. Дэлхийн хамгийн өндөр үнэлгээтэй компани болох тус корпораци FactSet-ийн таамаглалыг ерөнхийдөө давсан үр дүн мэдээлсэн бөгөөд пүрэв гарагт хувьцааны ханш бага зэрэг буурсан ч, тайлангийн үзүүлэлтүүд нь хиймэл оюун ухаан салбарын сүүлийн үеийн болгоомжлолыг намжаахуйц хангалттай хүчтэй байлаа. Энэ өсөлт нь энэ жил индексүүдийг бүх цаг үеийн дээд түвшинд хүргэхэд түлхэц болсон билээ.

ТРАМП: ХОЛБООНЫ НӨӨЦИЙН ЗАХИРАГЧИЙГ ОГЦРУУЛНА ГЭЖ МЭДЭГДЭВ

АНУ-ын Ерөнхийлөгч Дональд Трамп Холбооны нөөцийн захирагч Лиза Күүкийг моргейжийн луйвар үйлдсэн гэх мэдэгдлээр огцруулна гэж зарласны дараа Холбооны нөөцийн хараат бус байдал алдагдаж болзошгүй гэсэн болгоомжлол энэ долоо хоногт анхаарлын төвд орлоо. Күүк пүрэв гарагт огцруулах шийдвэрийг зогсоохоор шүүхэд нэхэмжлэл гаргасан бөгөөд Холбооны нөөцийн хэвлэлийн төлөөлөгч шүүхийн ямар ч шийдвэрийг дагана гэж мэдэгдэв. Мөн захирагч Кристофер Уоллер, хамгийн сүүлийн хурлын үеэр 25 суурь нэгжээр (0.25 хувь) бодлогын хүүг бууруулахыг санал болгосон тэрээр, пүрэв гарагт дахин байр суриа илэрхийлж, ирэх есдүгээр сарын уулзалтаар мөн 25 суурь нэгжээр бууруулахыг дэмжинэ гэв. Тэрбээр цаашид “дараагийн 3–6 сарын хугацаанд нэмэлт бууралтууд” хийгдэхийг хүлээж байгаагаа онцолж, “хөдөлмөрийн зах зээлд эрсдэл нэмэгдсэн” болон “эдийн засгийн үйл ажиллагаа мэдэгдэхүйц удааширсан” гэдгийг дурдлаа.

Golomt_Capital created with TradingView.com, Aug 31, 2025 23:29 UTC-4

NASDAQ 100 E-mini Futures - 1M - CME O23,479.00 H23,552.50 L23,433.75 C23,443.75 -10.75 (-0.05%) -10.75 (-0.05%)






Хөрөнгийн зах зээлийн онцлох мэдээ 2025.08.24 – 08.31

АНУ-БНХАУ-ЫН ХУДАЛДААНЫ ХАРИЛЦАА ТОГТВОРЖИЖ ӨСӨЛТ ҮРГЭЛЖИЛЛЭЭ

БНХАУ-ын хөрөнгийн зах зээл өсөлтөө үргэлжлүүлэн, сүүлийн үеийн эрчээ хадгаллаа. CSI 300 индекс 2.71%-иар, Шанхайн нийлмэл индекс 0.84%-иар (орон нутгийн валютын дүнгээр) өссөн гэж FactSet мэдээлэв. Харин Хонконгийн Hang Seng индекс 1.03%-иар буурав.

Сүүлийн хэдэн долоо хоногт Хятадын хөрөнгийн зах зээл хүчтэй өсөлттэй байна. CSI 300 зөвхөн наймдугаар сард ойролцоогоор 10%-иар өсөж, томоохон индексүүдийн дундаас хамгийн сайн гүйцэтгэлтэйд тооцогдож байгаа бөгөөд энэ сарын дундаж өдөр тутмын арилжааны хэмжээ түүхэн дээд түвшинд хүрэх төлөвтэй гэж Bloomberg мэдээлжээ. Олон шинжээчдийн үзэж буйгаар эдийн засгийн бодит өсөлтөөс илүүтэйгээр дотоодын хөрвөх чадвар өсөлтийг дэмжиж байгаа бөгөөд бэлэн мөнгөтэй өрхүүд хөрөнгө оруулалтын боломж хомс нөхцөлд өндөр өгөөж хайж байгаа нь гол шалтгаан болж байна. Мөн хувьцаа худалдан авахад зориулагдсан зээлийн хэмжээ 2015 оноос хойш хамгийн өндөр түвшинд хүрсэн нь жижиглэнгийн хөрөнгө оруулагчдын оролцоо нэмэгдсэнийг харуулж байна.

Эдийн засгийн үзүүлэлт талаас авч үзвэл, Хятад долдугаар сард үйлдвэрийн салбарын ашиг 1.5%-иар буурсан ч энэ нь шинжээчдийн таамгаас бага дүн гарчээ. Технологийн салбарын ашиг нь сул эрэлт болон дефляцийн дарамтад орсон бусад салбарын сулралыг нөхсөн байна. Гэсэн хэдий ч энэ сарын эхээр гаргасан бусад үзүүлэлтүүд нь Хятадын эдийн засаг долдугаар сард эрчээ алдаж, жижиглэн худалдаа, үйлдвэрийн үйл ажиллагаа, үндсэн хөрөнгийн хөрөнгө оруулалт хүлээлтэд хүрээгүйг харуулжээ. Ирэх саруудад гарах тоон мэдээллүүд Хятадын өсөлт удаашрах эсэхийг шийдэх бол худалдааны дайны нөлөөг зөөлрүүлэх зорилгоор магадгүй ирэх есдүгээр сараас эхлэн илүү их эдийн засгийн дэмжлэгийн бодлого хэрэгжүүлнэ магадлалтай.



Хүснэгт 1: Өнгөрсөн долоо хоногт тайлангаа зарласан компаниуд

Monday		Tuesday		Wednesday		Thursday		Friday
Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open

http://eps.sh/cal © 2025 Earnings Whispers

Хүснэгт 2: Энэ долоо хоногт тайлангаа зарлах компаниуд

Monday		Tuesday		Wednesday		Thursday		Friday
Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open

http://eps.sh/cal © 2025 Earnings Whispers